# БАЯНХОНГОР АЙМАГ
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
# ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 09 өдөр Дугаар Б/126 Номгон

Цалингүй чөлөөний хугацаа дууссан
Ч.Отгонсүрэнг ажилд нь үргэлжлүүлэн
ажиллуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.3 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Цалингүй чөлөөний хугацаа дууссан дуучин Ч.Отгонсүрэнг 2019 оны 12 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн үүрэгт ажилд нь эгүүлэн томилсугай.

2. Ажлын байрны тодорхойлолтын дагуу үүрэгт ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, бүтээлч санаачлагатай ажиллахыг дуучин Ч.Отгонсүрэнд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2019 tushal
2519:05

**БАЯНХОНГОР АЙМАГ**
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 11 өдөр Дугаар Б/127 Номгон

Б.Батцэнгэлтэй Хөдөлмөрийн
түр гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23.2.2, 23.2.3, $23^1$.1, $23^1$.2 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Ажилд орох хүсэлтээ ирүүлсэн Б.Батцэнгэлийг 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн жижүүрээр авч 3 сарын хугацаатай Хөдөлмөрийн түр гэрээ байгуулсугай.

2.Жижүүр Б.Батцэнгэлийг ТҮ-1 дүгээр зэрэглэлийн 2 дугаар шатлалаар цалинжуулахыг нягтлан бодогч Ч.Энхжаргалд зөвшөөрсүгэй.

3.Ажлын байранд заагдсан үүрэгт ажлаа цаг тухайд нь бүрэн чанартай гүйцэтгэж, хувийн зохион байгуулалттай, санаачлагатай, хөдөлмөрийн зөрчилгүй ажиллахыг жижүүр Б.Батцэнгэлд даалгасугай.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2019 tushal
2519?07

**БАЯНХОНГОР АЙМАГ**
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 18 өдөр Дугаар А/128 Номгон

Жилийн ажлын үзүүлэлтээр хамт олноо хошуучлан ажилласан ажилчдад үр дүнгийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 50.1, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал авах нөхцлийг хангасан нэр бүхий албан хаагчдад үр дүнгийн нэмэгдэл олгосугай.

2.Үр дүнгийн нэмэгдэл урамшуулал олгох ажиллагсдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Жилийн эцсийн ажлын амжилтын урамшууллыг 2019 оны 12 дугээр сарын цалин дээр нэмэгдүүлэн олгохыг нягтлан бодогч Ч.Энхжаргалд зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2019 tushal
2519:09

**БАЯНХОНГОР АЙМАГ**
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр Дугаар Б/130 Номгон

Гэрлийн техникч Ц.Батбаярыг
ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гэрлийн техникч Цэвээн овогтой Батбаяр нь өндөр настны тэтгэвэрт гарах эрх үүсч, өргөдөл хүсэлт тавьсан тул 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Ц.Батбаярын ЭМД, НД-ын дэвтэрт холбогдох бичилт хийж баталгаажуулахыг хүний нөөцийн менежер С.Ганчимэгт даалгасугай.

3.Ц.Батбаярын эзэмшиж байгаа техник хэрэгслийг нүд үзэн хүлээлцэхийг нягтлан бодогч Ч.Энхжаргал, зохион байгуулагч Б.Долгорсүрэн, нярав Ж.Эрдэнэчимэг нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2519213

**БАЯНХОНГОР АЙМАГ**
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 20 өдөр Дугаар А/131 Номгон

Байгууллагын аварга шалгаруулах спортын олон төрөлт тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.1а заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын аварга шалгаруулах олон төрөлт тэмцээнийг 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, тэмцээний шагналд 650000 /зургаан зуун тавин мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2.Байгууллагын аварга шалгаруулах тэмцээний шагналын 650000 төгрөгийг нэг удаагийн тэтгэмжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч Ч.Энхжаргалд зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2019 tushal
2519215

**БАЯНХОНГОР АЙМАГ**
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 25 өдөр Дугаар А/132 Номгон

Гэрлийн техникч Ц.Батбаярт тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5, Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Өндөр настны тэтгэвэрт гарах болзол нөхцлийг хуулийн дагуу хангасан гэрлийн техникч Ц.Батбаярт 12 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний тэтгэлэг болох 6761100 /зургаан сая долоон зуун жаран нэгэн мянга нэг зуун/ төгрөгийг Төрийн сангаар дамжуулж олгосугай.

2.Ц.Батбаярт олгох 6761100 төгрөгийн тэтгэмжийг тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч Ч.Энхжаргалд зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2019 tushal

2519217

**БАЯНХОНГОР АЙМАГ**
ТӨР, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН СОНОМЫН ЛУВСАНВАНДАНГИЙН НЭРЭМЖИТ
**ХӨГЖИМТ ДРАМЫН ТЕАТРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 31 өдөр Дугаар Б/134 Номгон

Ж.Лхагвасүрэнг ажлын байр сэлгэн ажиллуулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38.1.2, 23.2.1, 26.1, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 2.7, 3.1.1, 3.1.7, 10.1.3 дугаар заалт, захиргаа, уран сайхны зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1.Жижүүрийн ажлын байранд Хөдөлмөрийн түр гэрээгээр ажиллаж байсан Ж.Лхагвасүрэнг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж, 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн гэрлийн техникчийн албан тушаалд шилжүүлэн томилсугай.

2.Ж.Лхагвасүрэнгийн жижүүрийн ажлын байртай холбоотой тооцоог хийж, гэрлийн техникчийн үүрэгт ажлыг хүлээлцүүлж, Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, ажлын байрны албан тушаалын үүрэг чиглэлийг танилцуулахыг хүний нөөцийн менежер С.Ганчимэг, нярав Ж.Эрдэнэчимэг нарт үүрэг болгосугай.

3.Гэрлийн техникч Ж.Лхагвасүрэнг ТҮСУ-3 дугаар зэрэглэлийн 2 дугаар шатлалаар цалинжуулж, хавсран гүйцэтгэж байгаа жолоочийн ажлыг хэвээр үлдээж, ажил хавсарсаны нэмэгдлийг ТҮ-2 дугаар зэрэглэлийн 2 дугаар шатлалийн 40 хувиар тооцон олгохыг нягтлан бодогч Ч.Энхжаргалд зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ПҮРЭВДАГВА

2019 tushal
2519?25